



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР**

Тэмүүжин 01, Сариг баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23119

Утас/Факс: 70-56-21-34

Цахим шуудан: hen.ndaatgal10001@gmail.com

2025. 06. 20 № 02/236.

танай _____-ны № _____-т

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАРТ**

Тус газрын 2025 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлэв.
Хавсралт: 06 хуудастай.

ДАРГА

Н.НЯМХАТАН



ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.06.20

№	Зохион байгуулах ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.1	Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг ажил олгогч, иргэд, даатгуулагч, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах;	СБХОХ, ЗХХ, ТТХ	Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 96 аж нэгж, байгууллагад сургалт хийж нийт 6565 иргэд, даатгуулагч хамрагдсан байна. Нээлттэй мэдээллийн сарын хүрээнд: - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль - Сайн дурын даатгалын талаар 3 удаагийн лайв хийж нийт 36000 хүний хандалт авсан байна. Тайлант хугацаанд тус газар нь өөрийн цахим хуудас, веб сайт, фейсбүүк, фэйж хуудсаар 115 мэдээлэл, постер оруулж мөн ГБХНХЯ, НДЕГ-с бэлтгэсэн мэдээ, мэдээллийг цахимаар олон нийтэд түгээсэн ба давхардсан тоогоор 296000 гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна. Сайн дурын даатгуулагчдад зориулсан “Та шимтгэлээ төлсөн үү” гэх ерөнхий орлогын мэдээлэлтэй, шимтгэл төлөх заавартай постерийг сар бүр цахим орчинд байршуулж хэвшсэн. Хэнтий аймгийн төв Хэрлэн сумын багууд, олон нийтийн хөдөлгөөн ихтэй гудамж талбай, Хүнс барааны дэлгүүрүүд, зах худалдааны төв, арилжааны банкуудад явууллын үйлчилгээ 2 удаагийн давтамжтай зохион байгуулсан. Мөн Хэнтий аймгийн ЗДТГазартай хамтран 18 сумдад нийт 21 удаагийн сургалтаар 857 иргэд даатгуулагчид хамрагдсан байна.

1.2	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн хэрэглээг сайжруулах зорилгоор иргэд, даатгуулагчид, ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авах, сайжруулах санал хүргүүлэх;	СБХОХ, ЗХХ, ТТХ	GOOGLE FORM дээр сэтгэл ханамжийн судалгааг байршуулан QR кодоор иргэд даатгуулагчаас авахад бэлэн болгон ажилласан. Мөн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж Сайн дурын даатгалын ач холбогдол, шимтгэлийн хувь хэмжээ, Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголттой холбоотой хичээлийг бэлтгэсэн байна.
1.3	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах;	СБХОХ, ЗХХ, ТТХ	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахаар сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгон асуумж бэлдэн ажиллаж байна.
1.4	Иргэд, даатгуулагчдаас утсаар болон цахимаар ирүүлсэн асуулт, санал хүсэлт, гомдлыг шуурхай шийдвэрлэх;	СБХОХ, ЗХХ, ТТХ	Нийгмийн даатгалын байгууллагад үйлчилгээ авахаар хандсан иргэн, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагч нарт үйлчилгээг бүрэн гүйцэд, чанартай, шуурхай, хүнд сурталгүй, үйлчилгээний талаар ойлгомжтой, тодорхой танилцуулан үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар ойролцоогоор 3396 даатгуулагчдад үйлчилсэн бол Call Pro үйлчилгээгээр 9590 дуудлага ирж иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээлэл өгч түргэн шуурхай ажилласан байна.
1.5	Ажил олгогчийн тайланг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар авах бэлтгэл ажил хангах;	СБХОХ, ЗХХ	Нийт 944 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 3-НД7,8 тайланг цахимаар батлагдсан маягтын дагуу сикос системд хүлээн авч тулган, хуулийн хугацаанд баталгаажуулан ажилласан. Программын сайжралттай холбоотойгоор 2025 оны 4 дүгээр сараас эхлэн тоон гарын үсгээр нийт ажил олгогчийн 53 хувь буюу 497 байгууллагын тайланг тоон гарын үсгээр хүлээн авсан байна.
2.1	Мэдээллийн цахим санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн мэдээ, судалгааг найдваргүй, шүүхийн шийдвэртэй, үйл ажиллагаа нь зогссон, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаар нь ангилах, байцаагч ажилчид, дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;	Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч	2025 оны хагас жилийн байдлаар 1721.1 сая төгрөгийн оны эхний авлагаас 1617.8 сая төгрөг буюу 94 хувийг барагдуулсан байна. Сар бүрийн 1, 15-нд шимтгэлийн авлага бууруулахад авсан арга хэмжээ, өр авлагын мэдээг НДЕГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийн талаар газрын хурал дээр болон хэлтсийн дарга, байцаагч, ажилтнуудад танилцуулан ажиллаж байна.

2.2.	Нийгмийн даатгалын шимтгэлийн найдваргүй өрийн талаарх судалгааг гарган хэрхэн шийдвэрлэх талаарх саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;	СБХОХ, ЗХХ	Эзэн холбогдогч нас барсан 11.7 сая төгрөг /Жижиг эрдэнэ ХХК/, эзэн холбогдогч байхгүй 6.9 сая төгрөг /Дорнод Монгол ХХК/ байна. Хагас жилийн байдлаар НДЕГ-т найдваргүй өрийн судалгаа өгөөгүй байна.
2.3	Хэнтий аймгийн Хэнтий аймаг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 419 дүгээр нээлттэй хорих ангитай хамтран ажиллаж нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулан, шийдвэр гүйцэтгэлийн тайлан мэдээг солилцон ажиллах;	СБХОХ, Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч	Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 419 дүгээр нээлттэй хорих ангитай хамтран ажиллаж шүүхийн шийдвэртэй 116.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 10.0 сая төгрөгийг барагдуулаад байна. Үлдэгдэл 106.6 сая төгрөгийн авлагын дийлэнх хувь буюу 72.6 хувь нь Бор-Өндөр сумын Бат-гурван Эрдэнэ ХХК-ийн өр байна. Тухайн авлага гүйцэтгэх ажиллагааны дараалаар 5 дугаарт эрэмбэлэгдэж байгаа бөгөөд авлага барагдуулалт удааширч байна. Мөн 1 дүгээр улиралд СБХО-ын Хэлтсийн дарга 2 удаа шийдвэр гүйцэтгэгчтэй биечлэн уулзаж тооцоо нийлж, цаашид шүүхийн шийдвэртэй авлагыг бүрэн барагдуулахаар хамтран ажиллаж байна.
2.4	Үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа сэргэсэн эсэхийг тогтоох ажлыг зохион байгуулж, хуримтлагдсан шимтгэлийн өрийг барагдуулах, шаардлагатай тохиолдолд хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;	СБХОХ, ЗХХ	2025 оны хагас жилийн байдлаар ажил зохион байгуулаагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй байна.
2.5	100.0 сая төгрөгөөс дээш, 271 ба түүнээс дээш хоногийн насжилттай хуримтлагдсан өр үүсгэсэн аж ахуйн нэгж, байгууллагуудад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийх, шимтгэлийг төлүүлэх талаар холбогдох ажлыг зохион байгуулах;	СБХОХ, ЗХХ	100.0 сая төгрөгөөс дээш өр үүсгэсэн Эрдэнэс критикал минералс ТӨҮГ, Хэнтий ус ХХК, Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудын хувьд Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд байгаа бөгөөд оны эхний шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр үүссэн авлагыг барагдуулахыг сануулж утсаар болон дарга удирдлагатай уулзалт зохион байгуулж, тайлбар авах, данс хаах, албан шаардлага хүргүүлэх зэрэг арга хэмжээ авч ажилласан. Нэгдсэн эмнэлгээс 2025.04.15-ны өдөр №01/272 тоот албан бичиг ирүүлж эрүүл мэндийн даатгалын

			хэлтсээс 1 улирлын санхүүжилт гүйцэд орж ирээгүйн улмаас авлага үүссэн тайлбар өгсөн. НДЕГ-с төсөвт байгууллагын дансыг хаахгүй байх чиглэл өгсөн байна. Нэгээс дээш жилийн насжилттай нийт 132.0 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулахаар албан шаардлага өгч 16.7 сая төгрөгийн авлагыг барагдуулан, 110.4 сая төгрөгийн өртэй 7 байгууллагыг Шүүх хяналтын байгууллагат шилжүүлэн, 2.7 сая төгрөгийн өртэй 3 байгууллагын дансыг хааж ажилласан байна.
2.6	Нийгмийн даатгалын шимтгэлийн их хэмжээний өртэй, насжилт өндөртэй, найдваргүй болох эрсдэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэлийн өрийн судалгааг гаргаж, уулзалт зохион байгуулах, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөгдөхгүй байгаа нөхцөл байдал, шалтгааныг тодруулах, шаардлагатай мэдээллийг өгөх;	СБХОХ, Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч	100.0 саяас дээш болон 271 ба түүнээс дээш хоногийн насжилттай хуримтлагдсан өр үүсгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гарган уулзалт зохион байгуулан, тайлбар авах, данс хаах, албан шаардлага хүргүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна. Эрсдэлтэй аж ахуйн нэгж, байгууллага одоогоор байхгүй байна. Найдваргүй болох эрсдэлтэй авлага байхгүй байна. Дорнод Монгол ХХК-ийн өрийн баримт архиваас гарахгүй байгаа бөгөөд материалыг хайж байна.
2.7	Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг барагдуулах талаар аймгийн Засаг даргын тамгын газар, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллах, дээд шатны байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах;	Нийгмийн даатгалын газар	Хуримтлагдсан авлага үүсгэсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагуудын жагсаалтыг гарган Санхүү төрийн сангийн хэлтэст, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авдаг нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй эмнэлэг, эмийн сангуудын жагсаалтыг Эрүүл мэндийн даатгалын хэлтэст албан бичгээр хүргүүлэн барагдуулах, нэмж өр авлага үүсгэхгүй байхад анхаарч хамтран ажиллаж байна.
2.8	Арилжааны банкуудтай 2025 онд байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-нд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах заалтын хэрэгжилтийг хангах, хяналт тавьж ажиллах;	СБХОХ, ЗХХ	Хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 183 ажил олгогчийн 482,3 сая төгрөгийн авлагад дансны хаалт хийж барагдуулаад байна.

2.9	Хамтран ажиллах гэрээ, тушаал, журам, хамтын ажиллагааны хүрээнд мэдээлэл солилцон, үр дүнг тооцон ажиллаж байгаа байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг чанаржуулах, бодит үр дүнг өсгөх;	СБХОХ	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил болгон зарласантай холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар болон сургалт сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу НДЕХ-ийн шинэчилсэн найруулгыг цувралаар "Хэнтий мэдээ сонин"-той хамтран ажиллах гэрээ байгуулан иргэд даатгуулагчид мэдээлэл хүргэн нийгмийн даатгалын тогтолцоог олон нийтэд эергээр таниулж, мэдээ мэдээллийг хүртээмжтэй хүргэн ажилласан байна. Мөн Шүүх хяналтын байгууллагатай хамтран өр, авлагыг барагдуулан ажиллаж байна. Татварын байгууллагат бүртгэлтэй ААНБ-ын судалгаа авч идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй эсхийг шалган, хяналт тавин, хамруулахаар хамтран ажиллаж байна.
3.1	Нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлөхийг уриалсан, даатгуулагч, ажиллагчдад учрах эрсдэлийг ухуулан нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулсан, ажил олгогч, сурталчилсан, даатгуулагчид чиглэсэн сургалт, сурталчилгаа /контент бэлтгэх/ зохион байгуулах;	СБХОХ, ЗХХ, ТТХ	Нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлөхийг уриалсан, даатгуулагч, ажиллагчдад учрах эрсдэлийг ухуулан таниулсан, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчилсан, ажил олгогч, даатгуулагчид чиглэсэн контентыг 5 удаа бэлтгэж 11663 иргэд даатгуулагчид түгээн ажилласан байна.
3.2	А. Ажил олгогчид, даатгуулагчид, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;	ЗХХ	Нийтдээ хагас жилийн байдлаар 96 удаагийн сургалтаар 6565 иргэд даатгуулагчдад сургалт, мэдээлэл хүргэн ажилласан. Баг, хороонд 21 удаагийн сургалтаар 857 хүн хамруулж, оюутан суралцагчдад зориулсан нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалтыг 5 удаа зохион байгуулан 344 хүн хамруулсан мөн хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх сургалтыг 44 удаа зохион байгуулж 2836 хүн хамрагдсан байна.
3.3	Б. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан даатгалын шимтгэлийн өр байгууллагын шимтгэлийн өр	СБХОХ, ЗХХ	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан байгууллагын шимтгэлийн өр хуримтлагдах нь ажилтан, албан хаагчдад хэрхэн нөлөөлөх, хуулийн

	хуримтлагдах нь ажилтан, албан хаагчдад хэрхэн нөлөөлөх, хуулийн зохицуулалтыг таниулах сургалт зохион байгуулах;		зохицуулалтыг таниулах зорилгоор 28 удаагийн сургалтыг зохион байгуулж 2404 албан журмын даатгуулагч хамруулсан байна.
3.4	В. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад нийгмийн даатгалын тайлан, шимтгэл төлөлтэй холбоотой сургалт зохион байгуулах; Нийгмийн даатгалын SICOS системд бүртгэлтэй ажил олгогчдын хуулийн этгээдийн төрөл, ангилал, өмчийн төрөл, хэлбэрээр нь бүртгэлдүүлэх, ажил олгогчийн мэдээллийг боловсронгуй, хүртээмжтэй болгох;	СБХОХ, ЗХХ	Нийгмийн даатгалын тайлан, шимтгэл төлөлтийн талаар төсөвт байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, ажилтнуудад танхимаар болон цахимаар сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад нийт 124 нягтлан бодогч, ажилтнууд хамрагдсан байна.
4.1		СБХОХ	Энэ онд шинээр 43 ажил олгогчийг төрөл, ангилал, өмчийн хэлбэрээр нь SICOS системд бүрэн бүртгэсэн байна.
4.2	Сумдын байцаагч ажилчдад нийгмийн даатгалын нэгдсэн систем ашиглах сургалт зохион байгуулах, мэдээ мэдээллээр хангах;	СБХОХ, ЗХХ, ТТХ	Нийгмийн даатгалын Ерөнхий газар болон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд УБ хотод нийгмийн даатгалын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад тэтгэврийн байцаагч Хонгорзул, тэтгэмжийн тогтоолт олголтын байцаагч Б.Алтансүвд нар хамрагдсан. Тус сургалтаар мэдээллийн sicos системийн талаар нэгдсэн ойлголттой болж сумдын байцаагчдыг сургах үүрэг бүхий сургагч багшаар бэлтгэгдсэн. Сургалтын хүрээнд газрын 16 албан хаагчдад танхимаар, сумдын 14 байцаагчдад цахимаар холбогдож sicos системтэй холбоотой заавар зөвлөмжийг өгч мэдээ мэдээллээр ханган ажиллаа.

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР